



**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 012

Улаанбаатар хот

┌ Үзүүлэх сургалт, туршлага солилцох өдөр ┐
зохион байгуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтыг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, харилцан суралцаж, туршлага солилцох зорилгоор Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран “Үзүүлэх сургалт, туршлага солилцох өдөр”-ийг 2015 оны 03 дугаар сарын 11-ны өдөр Хангарди ордонд зохион байгуулсугай.

2. “Үзүүлэх сургалт, туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай

3. “Үзүүлэх сургалт, туршлага солилцох өдөр”-ийг зохион байгуулахад шаардагдах 500.000/Таван зуун мянган төгрөгийг/ Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын уралдаан тэмцээний төсвөөс гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй

4. Дээрх ажлыг өндөр хэмжээнд зохион байгуулахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД

1150500027

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны ...03. сарын 09-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

Үзүүлэх сургалт, туршлага солилцох өдөр
зохион байгуулах үйл ажиллагааны төсөв

№	Зардлын нэр	Дүн
1.	Байгууллагын шагнал 1-р байр-1 х 250.0₮ 2-р байр 1 х 150.0₮ 3-р байр 1 х 100.0₮	500.000 төг
	Дүн	500.000 төг

Боловсруулсан
Хянасан

Б.Түвшинбаяр
О.Эрдэнэцэцэг